



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/634

Чингис хот

Мотоцикль, мопедийн хөдөлгөөнийг
түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдсан хальтиргаа гулгаа үүсэж тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарласугай.

2. Дээрх арга хэмжээний хүрээнд илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүн, явц байдлыг танилцуулахыг Цагдаагийн газрын дарга, сумдын Засаг дарга нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Б.Дарханбаатар/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011041